

FOREIGN INVESTMENT CLIMATE AND ITS CURRENT ISSUES AND PROBLEMS IN MONGOLIA

Nandin-Erdene.B (Doctorate, National University of Mongolia)

Abstract: A positive foreign investment climate is one of the most critical factors of social and economic development that enable a country to enhance economic growth, job creation and trade development. Thus, the government must accompany its FDI policy and strong support to FDI attractiveness. Mongolia mainly attracts as mining, telecommunication, construction industries over the last two decades. But, the government could not focus on strategic clarity that FDI matters to support export and reduce unemployment such as agriculture, information technology and education sectors.

Key words: foreign investment, climate, politics, policy, national security

Монгол улс 1990-ээд оны ардчилсан хувьсгалаар олон шинэчлэлийг зэрэг хийж чамгүй ололт, амжилтыг олсон ч ажилгүйдэл, инфляци, иргэдийн амьдралын төвшин, орлого гэх мэт нийгэм, эдийн засгийн өмнө тулгамдсан шийдвэрлэх асуудлууд урган гарсаар байна. Аймаг, нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад ажилгүй иргэдийн тоо 2016 оны 2-р улирлын байдлаар 131,9 мянга байгаа нь 2015 оны мөн үеийнхтэй харьцуулахад 34,6 мянган ажилгүй иргэдээр буюу 35,6 хувиар өсч ажилгүйдлийн төвшин 11,6 хувьтай байна. Энэ үзүүлэлт нь 2014, 2015 оныхтой харьцуулахад нэмэгдсэн төлөвтэй байна. Өрхийн нийгэм, эдийн засгийн 2016 оны 3-р улирлын судалгаагаар нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого 853,3 мянган төгрөг болж өмнөх оны мөн үеэс 84,4 (9 хувь) мянган төгрөгөөр буурсан ба нэг өрхийн сарын дундаж мөнгөн зарлага 2016 оны 3-р улиралд 926,2 мянган төгрөг болж өмнөх оны мөн үеийнхээс 10,4 мянган төгрөгөөр буурсан¹ үзүүлэлттэй байна. ДНБ-ий өсөлт 2016 оны 1-р улиралд 3,1 байсан бол 2-р улиралд 1,4 хувь 3-р улиралд -1,6 хувь болж буурсан байна. Эдгээр үзүүлэлтүүд нь эдийн засгийн хүрээ багасч агшсаныг харуулж байна. Дээрх

¹ Монгол улсын нийгэм, эдийн засгийн байдал, Монгол улсын Үндэсний Статистикийн хороо, <http://www.nso.mn>

асуудлыг шийдвэрлэхэд, улс орноо хөгжүүлэх, дэд бүтэц, үйлчилгээгээ сайжруулахад зайлшгүй улс төрийн намуудын нэгдсэн бодлого, түүгээр дамжин хэрэгжих хөрөнгө хэрэгтэй. Энэ хөрөнгийг дотоодын эх үүсвэрээс шийдэж хүрэлцэхгүй бол гадаадын эх үүсвэрийг ашиглан (гадаадаас татан авч) асуудлыг шийдвэрлэдэг байна.

ГХО-ын эрүүл орчныг бүрдүүлэгч хэд хэдэн хүчин зүйл байдаг. Тухайлбал, эдийн засгийн либералчлалын хүчин зүйлүүд (өмчлөл, дотоодын хувь хэмжээтэй холбоотой хязгаарлалтуудыг халах гэх мэт), эрүүл бизнесийн орчны хүчин зүйлүүд (улс төр, эдийн засгийн тогтвортой байдал, үйлдвэр худалдааны таатай бодлогууд, чадварлаг, боловсролтой ажиллах хүчин гэх мэт) болон хөрөнгө оруулалтыг дэмжих хүчин зүйлүүд (төрийн дарамтыг бууруулах, хөрөнгө оруулалтын урамшуулал гэх мэт) хэмээн бүлэглэж болно. ГХО-ыг амжилттай хэрэгжүүлсэн улсууд дээрхи нөхцлүүдийг бүрдүүлж түүнийг тогтвортой хадгалж чадсан байдаг. Жишээ нь, Сингапур улс газар нутаг, хүн амын хувьд жижиг, мөн байгалийн баялаггүй ч ГХО-ыг татсан асар туршлагатай. Стратегийн нарийн төлөвлөгөө боловсруулж, бизнесийн таатай орчныг бүрдүүлж, хөрөнгө босгохын тулд засгийн газрын агентлагуудаа чадваржуулж, чадварлаг боловсон хүчнийг татах замаар ГХО-д тулгуурласан эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгосон.

Монгол улсын ГХО-ын талаарх өнөөгийн бодлого нь Монгол улсын Үндсэн хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль, Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтын тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Татварын багц хууль, Өрсөлдөөний тухай хууль, Татварын ерөнхий хууль, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийгэм-эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Гадаад валютын бодлого, Хөрөнгө оруулалтын хоёр талт гэрээ, Хөрөнгө оруулалтын урамшуулал, Татварын 2 талт гэрээ, Хөдөлмөрийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, жил жилийн улсын төсөв зэрэг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүд болон хуульд тусгагдан хэрэгжиж байна. Эдгээр

баримт бичгүүдэд манай улсын дотоод, гадаадын хөрөнгө оруулалтын бодлогын үндсэн чиглэлийг тодорхойлж, эрхзүйн орчинг нь бүрдүүлдэг. Гадаадын хөрөнгө оруулалтын эрхзүйн зохицуулалттай холбоотой олон талт гэрээ, конвенцэд нэгдэн орсон. Үүнд: Олон улсын бараа худалдахад хөөн хэлэлцэх хугацааны тухай конвенц /1974/, Улс болон гадаад улсын иргэний хооронд хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх тухай Вашингтоны конвенц /1996/, Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Марракешийн хэлэлцээр /1996/, Бараа худалдах-худалдан авах олон улсын гэрээний тухай Венийн конвенц /1997/, Хөрөнгө оруулалтыг баталгаажуулах олон талт агентлагийг үүсгэн байгуулах конвенц /1998/. Үүнээс гадна орлогын албан татварыг давхардуулж ноогдуулахгүй байх болон татвар төлөхөөс зайлсхийхээс урьдчилан сэргийлэх тухай хэлэлцээрийг нийт 28 оронтой хийсэн байна².

Монгол улсад орж буй нийт хөрөнгө оруулалтыг салбараар авч үзвэл уул уурхай олборлолт, газрын тос 73,3%, худалдаа нийтийн хоол 17%, банк, санхүү 1,4%, тээвэр 1,3%, барилгын материал, инженер 0,9%, хөнгөн үйлдвэр 0,8%, боловсрол, шинжлэх ухаан, соёл 0,13% байна. Харин хөрөнгө оруулж буй улсуудаар үзвэл БНХАУ 38%, Гонг Конг 13%, АНУ 13%, Сингапур 3%, Австрали 3% улс тус тус байна. Хөрөнгө оруулагч улсуудаас БНХАУ, Сингапур, Япон, АНУ-ын ГХО нэмэгдсэн бол бусад орнуудаас оруулсан ГХО буурсан үзүүлэлттэй байна³. Мөн хөрөнгө оруулалтын дийлэнх хувийг уул уурхай, олборлолт, газрын тос, худалдаа, нийтийн хоолны салбар эзэлж байна. Үүнээс харахад бусад салбарт хөрөнгө оруулалтыг татах зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна. Хөрөнгө оруулж буй салбар, улсыг харьцуулан авч үзвэл уурхай олборлолт, газрын тосны салбарт 73,3%, БНХАУ-аас орж ирсэн хөрөнгө оруулалтын хэмжээ 38% байгаа нь монгол улсын үндэсний аюулгүй байдалд нөлөөлж болох хүчин зүйл гэж үзэж байна. Тухайлбал, 2014 оны байдлаар Хятад улс нийт ГХО-ын 38%-ийг эзэлж байгаа нь үндэсний аюулгүй байдлын бодлогод онцгой анхааран ажиллах хэрэгтэйг харуулав. Үндэсний аюулгүй байдлын бодлого нь ГХО-ын бодлоготой шууд холбогддог. Монгол улсад хөрөнгө оруулж буй аль нэг улс нийт хөрөнгө

² Д.Мөнхцэцэг, П.Гантөмөр, Гадаадын хөрөнгө оруулалтын талаар баримтлах зохистой бодлого, 2015, 663-р тал

³ Монгол банк, Гадаад секторын тойм

оруулалтын 1/3-ээс ихгүй хөрөнгө оруулалт хийх ёстой байдаг. Хятад улсаас орж буй хөрөнгө оруулалт мөн уул уурхай олборлолт, газрын тосны салбарт хийгдэж буй хөрөнгө оруулалтыг хязгаарлах бус бусад улсаас татах хөрөнгө оруулалтын хэмжээ, бусад салбарт хийгдэх хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх улс төрийн бодлогыг хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

ДҮГНЭЛТ

1. ГХО монгол улсад зайлшгүй шаардлагатай хүчин зүйл юм. Учир нь ГХО нь ажлын байр нэмэгдүүлэх, бэлэн мөнгө урсгалыг нэмэгдүүлэх, шинэлэг техник технологийг нэвтрүүлэх зэрэг нийгэм, эдийн засгийн олон ач холбогдолтой.
2. Монгол улсад ГХО-ын талаар баримтлах төрийн нэгдсэн бодлого хэрэгтэй. Энэхүү бодлогын зарчмыг баримтлан бодлогын залгамж чанарт онцгой анхааран ажиллах нь ГХО-ыг татах, нэмэгдүүлэх үйл ажиллагаанд эерэгээр нөлөөлөх нь харагдаж байна.
3. ГХО-ыг нэмэгдүүлэх, татах төрийн бодлогод үндэсний тусгаар тогтнол, аюулгүй байдлын үзэл баримтлалыг онцгой анхааран тусгах хэрэгтэй байна.
4. ГХО-ын орчинг сайжруулахад шаардлагатай хүчин зүйлст анхааран түүнийг сайжруулахад олон талын үйл ажиллагааг зохион байгуулж судалгаа шинжилгээний ажлыг идэвхтэй, тасралтгүй хийх шаардлага нэн чухал байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

1. Монгол банк, Гадаад секторын тойм
2. Д.Мөнхцэцэг, П.Гантөмөр, Гадаадын хөрөнгө оруулалтын талаар баримтлах зохистой бодлого, 2015, 663-р тал
3. Монгол улсын нийгэм, эдийн засгийн байдал, Монгол улсын Үндэсний Статистикийн хороо
4. UNESCAP, 2003, FDI in Central Asian and Caucasian economies, p15
5. OECD, 2003, Checklist for FDI incentive policies, p.20